

ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДОТООД АУДИТ ХИЙСЭН ТАЙЛАН

I. Тайлангийн хураангуй

1.1 Нийтлэг үндэслэл

Дотоод аудиторын үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөний дагуу Хууль зүйн сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, 14.2.10-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэсэн заалтыг үндэслэн дотоод аудит хийж дүгнэлт, илэрсэн асуудалд чиглэсэн зөвлөгөө өгөх, цаашид үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд оршино.

1.2 Дотоод аудитын зорилго

Тус сургуулийн санхүүгийн үйл ажиллагааны үр нөлөөтэй байдлыг үнэлж дүгнэх, үүсээд байгаа асуудлуудын нөхцөл байдлыг үнэлэх, тус байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн үндэслэл, зөвлөгөө өгөх, байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх цаашдын арга хэмжээний санал боловсруулан гүйцэтгэх удирдлагад танилцуулах зорилготой.

1.3 Дотоод аудитын хамрах хүрээ

1.3.1 Хууль зүйн сургуулийн 2023, 2024 оны 1 дүгээр улирлын санхүүгийн үйл ажиллагаа

- Сургуулийн захиргаа
- Сургуулийн 2 тэнхим
- Сургуулийн 3 төв

1.3.2 Тайлан мэдээ

- 2023 оны санхүүгийн тайлан холбогдох хавсралтууд;
- 2023 оны төсвийн гүйцэтгэл, холбогдох тушаал шийдвэр;
- 2024 оны 1 дүгээр улирлын төсвийн гүйцэтгэлийн тайлан;
- 2024 оны 1 улирлын харилцах, кассын гүйлгээ, холбогдох тушаал шийдвэр
- 2023 оны мөнгөн хөрөнгийн ерөнхий журнал гүйлгээ;
- 2022-2023 он хичээлийн жилийн тайлан, 2023 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлан;
- Дээрх хугацаанд холбогдох /суралцагчийн хичээл сонголтын төлөвлөгөө, гүйцэтгэл, багшийн цагийн ногдол, гүйцэтгэлийн түүвэр тайлан/

1.4 Баримталсан аудитын стандартууд: АДБОУС-3000/118, АУДБОУС-3000/119, АУОС 2400, 2410, 2410А1, 2410А2, 2410А3, 2420, 2421, 2430, 2431, 2440, 2440А1

1.5 Ашигласан арга зүй: АУОС 2300, 2310, 2320, 2330

1.6 Нотлох зүйлийн хэлбэрүүд: Аман, баримтат, биет, дүн шинжилгээ

1.7 Тайлангийн үндсэн хэсэг

1.8 Дүгнэлт

1.9 Дотоод аудиторын санал, зөвлөмжүүд

УДИРТГАЛ

МУИС-ийн Ректорын баталсан 2024 оны дотоод аудит хийх төлөвлөгөө, Ректорын ажлын албаны даргын 2024 оны 2 дугаар сарын 26-ны 1а/449 тоот удирдамжаар Хууль зүйн сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж илэрсэн асуудалд чиглэсэн зөвлөгөө өгөх, цаашид үүсэх эрсдэлээс хамгаалах зорилгоор санал боловсрууллаа.

Тус сургуулийн үйл ажиллагаанд аудит хийсэн гол асуудал нь санхүүгийн тогтвортой байдлыг үнэлэх, Удирдах зөвлөлийн баталсан төсвийн хэрэгжилт, Гүйцэтгэх удирдлагын шилжүүлсэн санхүүгийн эрхийн хүрэн дэх хэрэгжилт гүйцэтгэлийн байдал, асуудлыг тодорхойлоход чиглэсэн. Санхүүгийн тогтвортой байдлыг үнэлэхэд хөндлөнгийн байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан мэдээ, холбогдох хавсралт, албан ёсны тайлангуудын тоо мэдээ, холбогдох хүмүүсийн баталгаажуулж гаргаж өгсөн баримтуудад тулгуурлав. Санхүүгийн тогтворжилт, төлбөрийн чадварын үнэлгээнд үйл ажиллагааны онцлогоос хамаарч бэлэн төлбөрийн хэрэгсэл их хэрэглэгддэг учир эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн эх үүсвэр, төсөв, төсвийн гүйцэтгэл нь гол бүрэлдэхүүн гэж авч үзлээ.

Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

- Сургуулийн санхүүгийн үйл ажиллагаа, эрсдэлийн талаар холбогдох баримт бичигтэй танилцах, мэдээлэл олж авах;
- Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны талаар тайлбар танилцуулга сонсох, ярилцлага хийх;
- Сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд үүсээд байгаа асуудлуудын нөхцөл байдлыг үнэлэх;
- Шилэн дансны болон аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний хэрэгжилт;
- Дотоод аудитын тайлан бэлтгэж санал боловсруулан гүйцэтгэх удирдлагад танилцуулах.

Санхүүгийн тайланг шинжлэн асуудал, эрсдэл байж болзошгүй хэсгүүдийг нарийвчлах, зайлшгүй холбогдох хэсгүүдийг түүвэрлэн гүйцэтгэсэн ба хөрөнгө санхүү зарцуулах нотлох баримт тушаал шийдвэр, холбогдох дүрэм, журмын хүрээнд хийгдсэн эсэх талаар баталгаажуулан зөрчлийг илрүүлэх, цаашид засан залруулах боломжуудыг зөвлөх, бодитой оршин байх, иж бүрэх байх, эрх үүрэг, хяналт, үнэн зөв, үнэлгээ ба хуваарилалт, тайлагнал зэргийг тулган баталгаажуулах, холбогдох ажилтнуудтай ярилцлага хийх зэргээр биет горимыг гүйцэтгэсэн. Түүнчлэн санхүүгийн шинээр нэвтрүүлж буй системийн явц, ашиглалт, хэрэглээний талаар ажиглалт хийлээ. Бараа материал, эд хөрөнгийг биетээр тулган оршин байгаа эсэхийг нотлох нөхцөл (системийн нэвтрүүлэлт удаашралтай, ажиллахгүй байгаатай холбоотой БМ, хөрөнгийн эргэлт хийгдээгүй) хязгаарлагдмал байсан.


Дотоод аудитын тайлангаар дотоодод байгаа асуудалд дүн шинжилгээ хийсэн ба ямар нэгэн хариуцлага хүлээлгэх бус цаашид сургуулийн үр дүнг сайжруулах, эрсдэлээс хамгаалах, МУИС-ийн бүрэлдэхүүний сургууль, нэгжүүд нэгдсэн бодлого, нэг дүрэм журмын хүрээнд үйл ажиллагааг явуулж байх зорилгын хүрээнд илэрсэн асуудалд санал зөвлөмжийг хүргүүлж байна.

ХОЁР. ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛИЙН САНХҮҮГИЙН БАЙДАЛ

2.1 Ерөнхий мэдээлэл

Хууль зүйн сургууль нь нийтийн болон хувийн эрх зүй гэсэн мэргэжлийн хоёр тэнхимтэй, сургалтын үйл ажиллагааг эрхлэн явуулдаг байна. Мөн "Практик сургалтын төв", Японы болон Солонгосын эрх зүйн боловсролын төв, "Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн", "Эдийн засаг, бизнесийн эрх зүйн төв", "Харьцуулсан эрх зүй, олон улсын эрх зүйн төв" гэсэн төвүүдээр дамжуулан зэргийн бус сургалт, судалгааны үйл ажиллагаа явуулснаас гадна сургуулийн эрдмийн зөвлөл, захиргааны зөвлөл, тэнхим, төвүүдийн эрхлэгч нар МУИС-ийн дүрэмд заасны дагуу сургуулийн сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиг үүрэгтэйгээр ажиллаж байна. 2023 оны статистикаар тус сургууль нь захирал 1, зөвлөх профессор 3, профессор 2, дэд профессор 9, ахлах багш 11, багш 19, дадлагажигч багш 2, гэрээт багш 17, захирлын туслах 1, тэнхим, төвийн туслах 4, сургалтын үйлчилгээний 3, нягтлан бодогч 2, хангамж үйлчилгээний 9 ажилтан, нийт 82 багш, ажилтантай, нийт 2333 суралцагчдаас 1535 суралцагч буюу 65.8 хувийн идэвхтэй суралцагчидтай үйл ажиллагаа явуулж байна. Батлагдсан бүтэц орон тооны сул орон тоо 3.5 хувьтай байна.

Зураг 1.Бүтэц, орон тоо, суралцагчид



Суралцагчид	2020-2021			2021-2022			2022-2023		
	Нийт	Идэвх-тэй	Идэвх-гүй	Нийт	Идэвх-тэй	Идэвх-гүй	Нийт	Идэвх-тэй	Идэвх-гүй
Бакалавр	1575	1421	154	1463	1238	225	1606	1258	348
Магистрант	592	198	394	355	201	154	607	237	370
Докторант	156	22	134	58	33	25	120	40	80
Дүн	2323	1641	682	1876	1472	404	2333	1535	798

Эх сурвалж:ХЗС-ийн санхүүгийн тайлан, МУИС-ийн цалин, орон тооны тушаал, 2021-2022, 2022-2023 оны хичээлийн жилийн тайлан.

2.2 Сургуулийн хөрөнгө, эх үүсвэрийн бүрэлдэхүүн

Хууль зүйн сургуулийн нийт хөрөнгө 2023 оны жилийн эцсийн тайлангаар 6.1 тэрбум төгрөгт хүрсэн байна. Үүний 91.89 хувь эргэлтийн хөрөнгө, үлдсэн 8.11 хувь нь эргэлтийн бус хөрөнгө эзэлж байна. Эргэлтийн хөрөнгийн бүтцийг 5 жилийн дунджаар харуулбал 76.93, авлага 6.58, бараа материал 2.04, урьдчилж гарсан зардал, бусад 1.19 хувьтай байна.


Эргэлтийн бус хөрөнгийн бүтцийг 5 жилийн дунджаар (цэвэр дүн) харуулбал сургалтын тоног төхөөрөмж 4.47, тавилга эд хогшил 3.94, ном сурах бичиг 4.54, биет бус хөрөнгө, нийтийн тохижилт бусад хөрөнгө үлдсэн хувийг эзэлж байна. Үндсэн хөрөнгө 58.%-ийн элэгдэлтэй байна. Эргэлтийн хөрөнгийн дийлэнх хувийг ХЗС-ийн хичээлийн байрны барилгын хуримтлал эзэлж байна. Хуримтлалыг эрсдэлээс хамгаалахын тулд өдөр бүр харилцах болон хадгаламжийн хүүг судлан мөнгөн хөрөнгийг байршуулж байна.

Хүснэгт 1. Хууль зүйн сургуулийн санхүүгийн байдлын тайлан (2019-2023)

сая төгрөгөөр

№	Утга	Балансын үлдэгдэл (сая.төг)					Хувийн жин					5 жилийн дундаж
		2019	2020	2021	2022	2023	2019	2020	2021	2022	2023	
1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ												
1.1	Мөнгө	2,027.46	2,812.09	4,076.20	4,959.31	5,638.05	72.36	64.95	79.57	83.43	84.36	76.93
1.2	Авлага ба бусад тооцоо	61.91	798.81	321.14	160.74	217.94	2.21	18.45	6.27	2.70	3.26	6.58
	Үүнээс: төлбөрийн авлага	42.54	757.65	305.87	109.49	106.44	1.52	17.50	5.97	1.84	1.59	5.68
1.3	Бараа материалын нөөц	70.39	74.27	112.84	110.10	127.89	2.51	1.72	2.20	1.85	1.91	2.04
	Үүнээс: хангамжийн материал	70.39	74.27	112.84	110.10	127.89	2.51	1.72	2.20	1.85	1.91	2.04
	түүхий эд материал						-	-	-	-	-	-
	мал амьтад						-	-	-	-	-	-
1.4	Урьдчилж гарсан зардал,	8.59	29.40	29.40	121.54	157.44	0.31	0.68	0.57	2.04	2.36	1.19
	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,168.35	3,714.57	4,539.58	5,351.68	6,141.32	77.39	85.80	88.62	90.03	91.89	86.74
2. ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ												-
2.1	Үндсэн хөрөнгө	993.31	1,021.48	1,092.84	1,195.84	1,203.84	35.45	23.59	21.33	20.12	18.01	23.70
	Хуримтлагдсан элэгдэл	(360.17)	(408.29)	(530.32)	(632.24)	(700.60)	(12.85)	(9.43)	(10.35)	(10.64)	(10.48)	(10.75)
	ҮХ-ийн цэвэр дүн	633.14	613.19	562.52	563.60	503.24	22.60	14.16	10.98	9.48	7.53	12.95
	Үүнээс: Барилга	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Сургалтын машин, т/т	254.05	221.46	195.75	168.13	100.38	9.07	5.12	3.82	2.83	1.50	4.47
	Тавилга, хэрэгсэл	198.45	205.33	169.09	160.17	126.31	7.08	4.74	3.30	2.69	1.89	3.94
	Номын фонд	180.65	186.40	197.68	235.30	276.56	6.45	4.31	3.86	3.96	4.14	4.54
2.2	Нийтийн тохижилт, бусад	-	-	19.80	29.31	38.75	-	-	3.87	4.93	5.80	2.92
2.3	Биет бус хөрөнгүүд	0.47	1.78	0.59	-	-	0.02	0.04	0.01	-	-	0.01
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	633.61	614.97	582.90	592.92	541.99	22.61	14.20	11.38	9.97	8.11	13.26
	Нийт хөрөнгийн дүн	2,801.96	4,329.54	5,122.48	5,944.60	6,683.31	100.00	100.00	100.00	100.00	100.00	100.00
3. ӨР ТӨЛБӨР												-
3.1.	Бараа үйлчилгээний өглөг			2.81	3.60	-	-	-	0.05	0.06	-	0.02
3.2.	Ажиллагчдад өгөх өглөг				-	-	-	-	-	-	-	-
3.3.	Бусад			0.26	32.33	10.63	-	-	0.01	0.54	0.16	0.14
3.4	Урьдчилж орсон орлого	246.49	426.59	361.26	456.08	609.70	8.80	9.85	7.05	7.67	9.12	8.50
	БХӨ-ийн дүн	246.49	426.59	364.33	492.02	620.34	8.80	9.85	7.11	8.28	9.28	8.66
	Урт хугацаатай өр төлбөр	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Нийт өр төлбөрийн дүн	246.49	426.59	364.33	492.02	620.34	8.80	9.85	7.11	8.28	9.28	8.66
4. ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ							-	-	-	-	-	-
4.1	Засгийн газрын оролцоо	307.56	307.56	307.56	307.56	307.56	10.98	7.10	6.00	5.17	4.60	6.77
4.2	Хуримтлагдсан үр дүн	2,247.91	3,595.39	4,450.59	5,145.03	5,755.41	80.23	83.04	86.88	86.55	86.12	84.56
	Үүнээс: тайлант оны	(157.44)	1,347.48	855.21	694.43	610.39	(5.62)	31.12	16.70	11.68	9.13	12.60
	Өмнөх үеийн	2,405.35	2,247.91	3,595.39	4,450.59	5,145.03	85.85	51.92	70.19	74.87	76.98	71.96
4.3	Дахин үнэлгээний нөөц						-	-	-	-	-	-
	Өмчийн дүн	2,555.47	3,902.94	4,758.15	5,452.58	6,062.97	91.20	90.15	92.89	91.72	90.72	91.34
	Өр төлбөр ба өмчийн дүн	2,801.96	4,329.54	5,122.48	5,944.60	6,683.31	100.00	100.00	100.00	100.00	100.00	100.00

Зураг 2. Эргэлтийн хөрөнгө (мянган төгрөгөөр)



2.4 Өр төлбөр ба өмч

Өр төлбөр ба эзэмшигчийн өмчийн 8.66 хувь нь өр төлбөр ба урьдчилж орсон орлого, үлдсэн хувийг Засгийн газрын оролцоо, хуримтлагдсан үр дүн, дахин үнэлгээний нөөц бүрдүүлж байна. Өр төлбөрийн 98.3 хувь нь урьдчилж орсон орлого буюу хичээл сонголт хийгээд цуцалсан оюутны сургалтын төлбөрийн буцаалт байна. 2023 оны жилийн эцсийн тайлангаар нийт эзэмшигчийн өмчийн 4.66 хувийг Засгийн газрын оролцоо, 86.12 хувийг тайлант хугацааны үр дүн эзэлж байна

Хүснэгт 2. Эзэмшигчийн өмчийн дүн (2019-2023) сая төгрөг, хувиар

№	Утга	Балансын үлдэгдэл (сая.төг)					Хувийн жин				
		2019	2020	2021	2022	2023	2019	2020	2021	2022	2023
4.1	Засгийн газрын оролцоо	307.6	307.6	307.6	307.6	307.6	10.98	7.10	6.00	5.17	4.60
4.2	Хуримтлагдсан үр дүн	2247.9	3595.4	4450.6	5145.0	5755.4	80.23	83.04	86.88	86.55	86.12
	Үүнээс: тайлант оны	-157.4	1347.5	855.2	694.4	610.4	-5.62	31.12	16.70	11.68	9.13
	Өмнөх үеийн	2405.3	2247.9	3595.4	4450.6	5145.0	85.85	51.92	70.19	74.87	76.98
4.3	Дахин үнэлгээний нөөц						0.00	0.00	0.00	0.00	0.00
	Өмчийн дүн	2555.5	3902.9	4758.2	5452.6	6063.0	91.20	90.15	92.89	91.72	90.72

Эх сурвалж: Хууль зүйн сургуулийн 2023 оны аудитаар баталгаажсан санхүүгийн тайлангаас

2.5 Санхүүгийн үр дүн

Хууль зүйн сургууль нь жил тутмын орлогын 90 гаруй хувийг сургалт, судалгааны орлогоор үлдсэн хувийг хадгаламжийн хүүгийн орлого, засгийн газрын хөнгөлөлт, бусад хандивын орлогоор бүрдүүлж ирсэн байна. Санхүүгийн 2023 оны тайлангаар үндсэн үйл ажиллагаанаас 5.9 тэрбум төгрөгийн орлого төвлөрч, 3.6 тэрбум төгрөгийг урсгал зардал зарцуулан 2.2 тэрбум төгрөг буюу 37.97 хувийн үр дүнтэй ажилласан байна. Сургуулийн үр дүнгээс 1.6 тэрбум төгрөгийг бүрэлдэхүүний сургууль, төвлөрсөн үйлчилгээний нэгж хоорондын тооцоонд шилжүүлэн зарцуулжээ. ХЗС-ийн сүүлийн 5 жилийн үндсэн үйл ажиллагааны орлого дунджаар 1.7 хувийн, урсгал зардал дунджаар 10.9 хувийн өсөлттэй байна. МУИС-ийн бодлогын хүрээнд татан төвлөрүүлэлтийг ХЗС-ийн хичээлийн байрны хөрөнгө оруулалтыг харгалзан сүүлийн 2 жил бууруулсан үзүүлэлттэй байна. Үүний үр дүнд барилгын хөрөнгө оруулалтад 4.0 тэрбум төгрөгийн хуримтлалыг бий болгосон хэдий ч үр дүн жил тутам буурсан үзүүлэлттэй байна. Өөрөөр хэлбэл орлогын өсөлт нь урсгал зардлын өсөлтийг гүйцэхгүй байна. Орлого үр дүнгийн тайлангаас харахад МУИС-ийн 2016-2024 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөний хүрээнд Хууль зүйн сургуулийн дунд хугацаанд хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан байгууллагын бие даасан байдал болон санхүүгийн тогтвортой байдлыг хангахад сургалтын төлбөр болон улсын төсвөөс бусад орлогыг нийт

орлогын 4 хувиас доошгүй хувь байх зорилт хангагдсан байна. Үүнд хадгаламжийн хүүгийн орлого гол нөлөө үзүүлжээ.

Хүснэгт 3. Санхүүгийн үр дүн (2019-2023), сая төгрөгөөр

Үзүүлэлт		Гүйцэтгэл, сая төгрөгөөр					2021-2023		2022-2023	
		2019	2020	2021	2022	2023	сая.₮	хувиар	сая.₮	хувиар
1. Үндсэн ажиллагааны	Орлого	5,508.16	5,295.93	5,425.84	5,658.19	5,871.90	446.06	8.22	213.71	3.78
	Зардал	2,427.53	2,534.08	2,631.17	3,260.76	3,642.39	1,011.22	38.43	381.63	11.70
	Үр дүн	3,080.63	2,761.85	2,794.67	2,397.43	2,229.51	(565.16)	(20.22)	(167.92)	(7.00)
	Орлогод харьцуулсан %	55.93	52.15	51.51	42.37	37.97	(126.70)	(245.99)	(78.57)	(185.44)
2. Үндсэн бус ажиллагааны	Орлого	0.065	0.179	0.001	1.739	9.709	9.71	730,712	7.97	458.30
	Зардал	3,238.13	1,414.55	1,939.47	1,704.73	1,628.83	(310.64)	(16.02)	(75.90)	(4.45)
	Үр дүн	(3,238.06)	(1,414.37)	(1,939.47)	(1,702.99)	(1,619.12)	320.35	(16.52)	83.87	(4.92)
	Орлогын 1 төгрөгт ногдох зардал (мөнгөөр)	1.03	0.75	0.84	0.88	0.90	0.05	6.39	0.02	2.16
3. Бүгд	Орлого	5,508.23	5,296.11	5,425.84	5,659.93	5,881.61	455.77	8.40	221.68	3.92
	Зардал	5,665.66	3,948.63	4,570.64	4,965.50	5,271.22	700.58	15.33	305.72	6.16
	Үр дүн	(157.44)	1,347.48	855.20	694.43	610.39	(244.81)	(28.63)	(84.05)	(12.10)
	Орлогын 1 төгрөгт ногдох зардал (мөнгөөр)	1.03	0.75	0.84	0.88	0.90	0.05	6.39	0.02	2.16

2.6 Санхүүгийн тогтворжилт, төлбөрийн чадварын үндсэн харьцаа

Санхүүгийн тогтворжилтын хувьд үзүүлэлтүүдийг нь өмнөх онуудтай харьцуулбал харьцангуй тогтвортой төсвийн санхүүжилт болон бусад гадаад эх үүсвэрээс хараат бусаар үндсэн ажиллагааны орлогоороо урсгал зардал төдийгүй хөрөнгө оруулалтын хэсгийг санхүүжүүлэх боломж байгааг илтгэж байна. Өөрийн хөрөнгийн оролцоо 90 хувиас буурахгүй тогтвортой байгаа нь бизнесийн байгууллагын хэвийн нормоос 40 орчим хувиар илүү, өрийн харьцаа 15 дахин бага буюу 0.07-0.10 хооронд байна.

Хүснэгт 4. Санхүүгийн тогтворжилтын үндсэн үзүүлэлт (2019-2023)

Үзүүлэлтүүд	2019	2020	2021	2022	2023
1.1 Өөрийн хөрөнгийн оролцоо	91.20	90.15	92.89	91.72	90.72
1.2 Нийт өрийн харьцаа	0.09	0.10	0.07	0.08	0.09
1.3 Ажлын цэвэр капитал (сая төг)	1,921.86	3,287.97	4,175.25	4,859.67	5,520.98
1.4 Санхүүгийн уян хатан байдал	75.21	84.24	87.75	89.13	91.06
1.5 Эргэлтийн хөрөнгийн санхүүжилт	88.63	88.52	91.97	90.81	89.90

Эх сурвалж: 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаас

2.7 Төлбөрийн чадварын үндсэн үзүүлэлт, хөрөнгийн ашиглалт

Эргэлтийн хөрөнгийн харьцааг харвал, эргэлтийн хөрөнгөөрөө богино хугацаат өр төлбөрийг барагдуулах чадварыг харуулдаг бөгөөд ХЗС нь бизнесийн байгууллагын стандарт нормоос 4.9 дахин илүү буюу төлбөрийн чадварын хувьд хангалттай сайн байна. Богино хугацааны өр төлбөр нь авлагын дүнгээс 2.8 дахин их ч нийт хөрөнгөд эзлэх хувь хэмжээ бага, төлбөрийн чадварт нөлөөлөх нөлөө сул байгааг илтгэж байна.

Хүснэгт 4 Төлбөрийн чадварын үндсэн үзүүлэлт, хөрөнгийн ашиглалт (2019-2023)

Үзүүлэлтүүд	2019	2020	2021	2022	2023
2.1 Өнөөгийн боломж	8.23	6.59	11.19	10.08	9.09
2.2 Ойрын боломж	8.48	8.46	12.07	10.41	9.44
2.3 Эргэлтийн хөрөнгийн харьцаа	8.80	8.71	12.46	10.88	9.90
2.4 Өр төлбөр ба авлагын харьцаа	3.98	0.53	1.13	3.06	2.85

Эх сурвалж: 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаас

Тайлант хугацааны санхүүгийн үр дүнг тооцоходоо МУИС-д мөрдөж байгаа НБББББ-ийн орлогын бүртгэлийн тусгай бодлогын 3.4.1-т заасан зарчмыг баримтлахгүй байна. НБББББ-ийн өөрчлөлтийг баримт бичигт тусгахгүй төв санхүүгээс аман зөвлөмжөөр бүртгэх, тайлагнах нь санхүүгийн тайлан үнэн зөв байхад эрсдэл үүсгэхээр байна.

2.8 Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хууль зүйн сургуулийн хувьд сургуулийн захирал нь батлагдсан төсвийн хүрээнд төсвийн орлого бүрдүүлэх, захиран зарцуулах эрх үүргийг хүлээн санхүүгийн үйл ажиллагааг удирдан ажиллаж байна. Төсвийг захиран зарцуулахад МУИС-ийн захирлын 2014 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн А/21 тоот тушаалыг үндэслэж байна. Төсвийн гүйцэтгэлийн тайланг орлогоо бүрдүүлсэн байдал, зардлыг төлөвлөсөн хэмжээнд зориулалтын дагуу зарцуулсан байдал, хөрөнгө мөнгөний үр өгөөж, зарим зардлыг хэмнэлттэй захиран зарцуулах боломжоо олж харах, өртгийг бодитой тооцсон эсэх, дунд хугацааны төлөвлөлт болон үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглүүлсэн эсэх, үр дүнг дээшлүүлсэн эсэх, тайлагналт бодитой эсэх зэргийг тодорхойлох үүднээс шинжиллээ.

2.8.1 Төсвийн орлогын гүйцэтгэлийн талаар

2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар нийт төсвийн орлого 1.44 хувиар давж биелсэн байна. Орлогын бүтцээр нь авч үзвэл бакалаврын сургалтын төлбөрийн орлого 153.0 сая төгрөгөөр тасарч, мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 37.4 сая, ахисан түвшний болон гадаад оюутны сургалтын төлбөр 34.9 сая, судалгаа, гэрээт ажил, төслийн орлого 145.2 сая, оюутны замын зардлын хөнгөлөлт 3.1 сая, түр сургалтын орлого 6.6 сая, хадгаламжийн хүүгийн орлого 363.1 сая, бусад орлого 12.0 сая буюу нийт 602.3 сая төгрөгөөр давж биелсэн байна. Дотоод тооцооны орлого төсөвлөсөн дүнгээс 229.2 сая төгрөгөөр буурсан нь бүрэлдэхүүн сургууль хооронд тооцоогоо орлого зарлагын зөрүү дүнгээр хийсэн нь нөлөөлсөн байна. ХЗС-ийн судалгааны төвүүдийн орлого төсөвлөсөн дүнгээс 95.8 сая төгрөгөөр тасарч харин гэрээт ажил, судалгааны төсөл төсөвлөсөн дүнгээс 145.2 сая төгрөгөөр давсан байна. Судалгааны орлогын гол нөлөө нь Европын холбооны санхүүжилттэй Ерасмус (336,000 евро) төсөл байна. Уг төслийн хүрээнд "Үндсэн хуулийн эрх зүй", "Харьцуулсан эрх зүй", "Эрх зүйт төр ба олон улсын эрх зүй"-н чиглэлийн бакалавр болон ахисан түвшний хичээлийн хөтөлбөрийг сайжруулах, хамтарсан эрдэм шинжилгээний хурал хийх, харилцан судалгаа хийх, оюутан солилцох чиглэлээр 3-н жилийн хугацаанд хамтран ажиллахаар болсон байна.

МУИС-ийн захиргаа төвлөрсөн сангаас төсөв батлагдсаны дараа 61.8 сая төгрөгийн оюутны хөгжлийн зээл, 36.6 сая төгрөгийн буцалтгүй тусламж, 6.4 сая төгрөгийн ЗГ-ын гэрээгээр суралцагчдын сургалтын төлбөрийн санхүүжилтийг хийсэн нь дотоод тооцооны орлогын дүнд нөлөөлсөн байна. Төсвийн төлөвлөлт хийхээс өмнө бүрэлдэхүүний сургууль, төвлөрсөн сан хоорондын экспорт, импортын болон БЗС, ЗГ-ын санхүүжилт зэрэг тооцоог нийлэн баталгаажуулах, тухайн онд нь санхүүжилтийг хийж дуусгах, эсвэл авлага өглөгөөр бүртгэн тайланд тооцоонд тусгах нь орлогын төсвийн үндэслэл сайжрах, илүү бодитой илэрхийлэгдэхэд эерэг нөлөөтэй.

Мөнгөн хөрөнгийг оновчтой байршуулан, илүү өгөөжтэй ашиглах тал дээр анхаарч ажилласан сайшаалтай байна. Цаашид төсвийн төлөвлөлтийн үед өмнөх оны хүлээгдэн буй гүйцэтгэл, тайлагнал, судалгааны төвүүдийн орлогыг нэмэгдүүлэхэд анхаарах, хичээл сонголт, харилцахын орлогын гүйлгээг тулган төв санхүүгээр хянуулан баталгаажуулах, хяналт тавин ажиллах шаардлага байна.

Хүснэгт 5. Хууль зүйн сургуулийн орлогын төсвийн гүйцэтгэл, сая төгрөгөөр (2023 он, 2024 оны 1 улирал)

Орлогын зүйл	2023 он			2024 оны 1 улирал		
	Төсөв	Гүйц	Зөрүү	Төсөв	Гүйц	Гүйц %
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	4921.9	4959.3	37.4	5462.0	5638.0	3.2
Улсын төсвийн санхүүжилт	7.9	11.1	3.2	11.5		-
Оюутны замын зардал	7.9	11.1	3.2	11.5		
Үндсэн үйл ажиллагааны орлого	5479.5	5410.7	(68.8)	6004.1	2551.2	42.5
Судалгаа, гэрээт ажил, төсөл хөтөлбөр	50.0	195.2	145.1	66.3	30.0	45.2
Судалгааны төвүүдийн орлого	100.0	4.2	(95.8)	70.0	2.0	2.9
Сургалтын орлого	5329.5	5211.4	(118.1)	5867.8	2519.2	42.9
Бакалаврын	4677.2	4524.2	(153.1)	5123.1	2164.3	42.2
Магистрантын	523.3	540.4	17.2	582.5	311.3	53.4
Докторантын	73.3	76.5	3.2	63.2	22.8	36.1
Гадаад оюутны	55.7	70.2	14.5	99.0	20.7	20.9
Туслах үйл ажиллагааны орлого	91.0	472.6	381.6	166.0	147.5	88.9
Түр сургалт	5.0	11.6	6.6	10.0		-
Хадгаламжийн хүүгийн орлого	80.0	443.1	363.01	150.0	146.8	97.9
Хураамж, бусад	6.0	18.0	12.0	6.0	0.8	13.3
Дотоод тооцооны орлого	451.4	222.2	(229.2)	427.5		-
Бүрэлдэхүүн сургууль, нэгж хоорондын	421.3	73.8	(347.6)	370.0		
Захиргаа төвлөрсөн үйлчилгээний						
Бусад		104.8	104.8			
Хос хавсарга хөтөлбөрийн дотоод тооцоо	30.1	43.7	13.6	57.5		
Хандив						
Нийт дүн	10951.8	11076.1	124.3	8336.8	3734.01	44.8

Эх сурвалж: Хууль зүйн сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан-ТГТ, 2024 оны төсвийн 1 улирлын гүйцэтгэл.

Хүснэгт 6. Хууль зүйн сургуулийн сургалтын төлбөрөөс бусад орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх чиглэлээр гаднын эх үүсвэртэй төсөл, гэрээт ажил, сая төгрөгөөр (2022-2023 он)

Д/д	Төсөл гэрээт ажил	Санхүүжүүлэгч байгууллага /хэрэгжүүлсэн нэгж	Санхүү-жилтийн дүн /мян.төг-өөр/	Хэрэгжих хугацаа
1	Хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын системчлэл арга зүй, тогтолцоо болон эрх зүйн актыг ангилагчийг шинэчлэн батлах төсөл 1 үе шат	Хууль зүйн үндэсний хүрээлэн	140.0	2022.12-2023.05
2	Хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын системчлэл арга зүй, тогтолцоо болон эрх зүйн актыг ангилагчийг шинэчлэн батлах төсөл 2 үе шат	Хууль зүйн үндэсний хүрээлэн	үргэлжлэл	
3	Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл	МУЗГ-ын Хэрэг эрхлэх газар		2023.03.15-
4	Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн төсөл	МУИХ		2022.12.10-
5	Байгаль орчны салбарын хуулиудын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах дүн шинжилгээ хийх, салбарын хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах	Global green growth institute	107.3	
6	Олон улсын Хүмүүнлэгийн эрх зүйн дотоодын хэрэгжилт	Гадаад хэргийн яам, Олон улсын Улаан загалмайн нийгэмлэг	34.9	2022.06.01-2023.06.01
7	Даатгалын тухай хууль, Жолоочийн хариуцлагын тухай хууль, Албан журмын даатгалын тухай хуулийн шинэчлэл найруулах	Санхүүгийн зохицуулах хороо	20.0	2022.02.01-2023.02.01
8	Амьтны эрхийн тухай хуулийн төсөл	Нээлттэй нийгэм форум		2022.04.01-2023.10.01
9	Баялагийн сангийн тухай хуулийн шинэчлэл	МУЗГ-ын Хэрэг эрхлэх газар		2023.03.14
10	Стандартчилал, хэмжил зүйн тухай хуулийн шинэчлэл	МУ-ын Шадар сайд		2022.10.26

11	Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй сурах бичиг	МУИС-ийн дотоод төсөл		
12	Хууль зүйн клиник сургалтын мониторинг судалгаа	Монголын хуульчдын холбоо	1.0	2022.01.01-2022.12.15
13	Стандарт ба хөгжил үндэсний хөтөлбөр боловсруулах	СХЗГ-ын дарга		2023.01.11-2023.03.16
14	Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэжлийн түвшнийг үнэлэх журамд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах	МУЗГ-ын Хэрэг эрхлэх газар		
15	Харилцаа холбооны салбар дахь бие даасан зохицуулах байгууллагын хуулийн этгээдийн статус, эрх зүйн байдлын судалгаа	Харилцаа холбооны зохицуулах хороо	79.9	2022.10.01-2023.04.30

2.8.2 Төсвийн зарлагын гүйцэтгэлийн талаар

Хууль зүйн сургуулийн 2023 оны төсөвлөсөн бүгд зардал 10.6 тэрбум төгрөг байна. Нийт зардал 2023 оны гүйцэтгэлээр 5.4 тэрбум төгрөг буюу 50.9 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс урсгал зардал 3.6 тэрбум төгрөг буюу 66.2 хувь, дотоод тооцооны зардал 1.8 тэрбум 33.8 хувь байна. Дотоод тооцооны 88.9 хувь буюу 1.6 тэрбум төгрөг нь захиргаа, төвлөрсөн сангийн төвлөрүүлэлт байна. Барилгын ажил эхлээгүй байгаатай холбоотойгоор төлөвлөсөн хөрөнгө оруулалтын зардал 4.0 тэрбум төгрөг хэмнэгдэн он дамжсан байна. Урсгал зардлыг бүтцээр харуулбал цалин, НДШ 49.05 хувь, байр ашиглалтын зардал 0.93 хувь, хангамж бараа материал 0.56 хувь, норматив зардал 0.01 хувь, эд хогшил, урсгал засварын зардал 2.09 хувь, томилолт зочны зардал 0.61 хувь, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 4.93 хувь, сургалтын үйлчилгээний зардал 3.84 хувь, оюутны үйлчилгээ 0.39 хувь, эрдэм шинжилгээ, төсөл хөтөлбөр 0.68 хувь, төсөл, гэрээт ажлын зардал 2.12 хувь, тусламж тэтгэвэр тэтгэмжийн зардал 0.69 хувийг эзэлж байна.

Төсвийг зарлагын эдийн ангилал, зүйл заалт, зориулалтын МУИС-ийн захирлын 2014 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн А/21 тоот тушаалыг үндэслэн санхүүжилтийг олгож ажилласан байна.

Хүснэгт 7. Хууль зүйн сургуулийн зарлагын төсвийн гүйцэтгэл сая төгрөгөөр

Зардлын зүйл	2023			2024.I ул		
	Төсөв	Гүйц	Өөрчлөлт	Төсөв	Гүйц	Гүйц%
УРСГАЛ ЗАРДАЛ	4533.1	3598.6	934.5	4811.5	864.2	18.0
Цалин, НДШ-ийн зардал	3067.8	2666.5	401.2	3104.8	634.3	20.4
Байр ашиглалтын зардал	65.6	50.6	43.5	75.6	16.8	22.2
Хангамж бараа материалын зардал	48.4	30.6	17.8	84.1	5.9	7.0
Норматив зардал	1.2	0.6	0.6	0.5	0.5	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	114.2	113.6	0.6	90.4	7.9	8.7
Томилолт, зочны зардал	80.4	33.0	47.5	97.5	7.1	7.3
Бусдаар гүйцэтгүүлсэн АҮ	273.8	268.1	5.6	227.0	23.0	10.1
Бараа үйлчилгээ, бусад дэмжлэг	18.2	15.9	2.3	43.3	0.5	1.2
Сургалтын үйлчилгээний зардал	363.9	209.0	154.9	452.1	62.2	13.8
Бичиг хэргийн	36.8	22.1	14.7	11.1	0.7	6.3
Дадлагын	46.1	20.8	25.3	64.0	3.6	5.6
Хичээл сургалтын	37.2	30.5	6.6	64.0	5.1	8.0
Хөтөлбөр арга хэмжээ	51.1	27.8	23.3	75.9	9.7	12.8
Мэргэжлийн олимпиад	67.7	40.7	27.0	94.8	24.6	25.9
Гадаад багш	26.5	10.1	16.4	33.5	1.3	3.9
Багш, сургалтын ажилчдын дэмжлэг	98.6	57.0	41.7	108.9	17.1	15.7

Оюутны үйлчилгээ	46.8	21.1	25.8	58.8	2.5	4.3
ЭШ, судалгаа, инновацын зардал	264.5	36.8	227.6	288.9	18.4	6.4
Төсөл, гэрээт ажилтай холбоотой зардал	150.0	115.5	34.5	249.0	85.2	34.2
Тусламж, тэтгэвэр тэтгэмжийн зардал	38.3	37.3	1.1	39.6	-	
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4015.6	-	4015.6	4864.8	5.1	0.1
Барилга байгууламж	4015.6		4015.6	4715.6	5.1	0.1
Сургалтын тоног төхөөрөмж				142.1		
Тавилга				7.1		
Дотоод тооцоо	2041.4	1839.4	202.0	2117.1	480.0	22.7
Бүрэлдэхүүн сургууль хоорондын	431.8	185.4	246.4	508.1		
Захиргаа, төвлөрсөн сангийн	1600.0	1600.0	-	1600.0	480.0	30.0
Хос, хавсарга хөтөлбөрийн дотоод тооцоо	9.6		9.6	8.9		
Бусад		54.0	(54.0)			
Нийт дүн	8548.7	5438.0	3110.7	11793.4	1349.3	11.4
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	361.7	5638.0	5276.4		6987.5	

Багшийн ногдол, цалин хөлс - урсгал зардлын 74.1 хувийг цалин НДШ эзэлж байна. Үүнийг зардлын бүтцээр нь харуулбал үндсэн цалин нь 79.2%, илүү цаг 8.3%, цагийн хөлс 6.8%, урамшуулалт цалин 3.1% байна. 2022-2023 оны хичээлийн жилийн багшийн А цагийн ногдол дунджаар 12ББц төлөвлөснөөс гүйцэтгэл 16ББц байна Нэг багшид ногдох илүү цаг 4.8ББц байна. Үүнд нөлөөлсөн нөлөөллийг сургалтын үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайланд дүн шинжилгээ хийснээр илүү тодорхой болно гэж үзлээ.


Хүснэгт 8. Багш, ажилчдын цалин хөлс, нэмэгдлийн төсөв, гүйцэтгэл (сая.төгрөгөөр)

Үзүүлэлт	2019 он		2020 он		2021 он		2022 он		2023 он	
	Төсөв	Гүйц	Төсөв	Гүйц	Төсөв	Гүйц	Төсөв	Гүйц	Төсөв	Гүйц
Үндсэн цалин, цол зэрэг	1,262.07	1,209.03	1,500.20	1,386.07	1,590.75	1,490.91	1,951.99	1,695.98	2,117.82	1,927.92
Илүү цаг	169.72	157.80	222.90	217.47	235.00	227.09	277.20	175.12	220.12	208.49
Урамшуулал	63.10	46.62	70.00	63.33	68.52	68.84	92.79	69.22	137.23	72.62
Цагийн хөлс	249.98	110.14	130.87	83.57	122.00	64.15	223.01	121.07	251.73	160.14
Дүн	1,744.87	1,523.59	1,923.97	1,750.44	2,016.28	1,850.99	2,544.99	2,061.39	2,726.90	2,369.17

Хууль зүйн сургуулийн 2020-2021, 2021-2022, 2022-2023 оны хичээлийн жилийн багшийн цагийн ногдлын гүйцэтгэлийн тайланг түүвэрлэн зарим багш нарын ногдол гүйцэтгэлийг шалгахад журамд заасан тоогоор анги дүүргэлт бүрдээгүй сургалтын үйл ажиллагаа явагдсан тохиолдол байна. Цаашид тайлант хугацааны нэгдсэн мэдээ тайланг нэгжээс гаргуулан захирал, санхүү, тэнхим хяналт тавин ажиллах, үйл ажиллагааг тогтмолжуулах шаардлага байна. Багшийн ногдлын гүйцэтгэл, анги бүрдэлтэд хяналт тавьж ажилласнаар сургалтын үйл ажиллагааг илүү үр дүнтэй зохион байгуулагдах сургуулийн үр дүн нэмэгдүүлэх боломж бий болно гэж үзэж байна. Хууль сургуулийн захирлын 2023.11.24-ны А/162 тоот тушаалаар “ V түвшний оюутны мэргэших дадлага удирдагчийн хөлсийг 155,000 төгрөг” - өөр тогтоон мөрдөж байгаа нь МУИС-ийн захирлын 2023.12.14-ны А/594 тоот “Цагийн хөлсний үнэлгээг шинэчлэн тогтоох” тухай тушаалтай нийцэхгүй байна. Иймд тус

хөлсний үндэслэл, аргачлалыг боловсруулан МУИС-ийн захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулах нь зүйтэй.

Зураг 3. Сургалтын төлбөрийн орлого болон цалин, НДШ-ийн өсөлтийн харьцаа.



Эх сурвалж: ХЗС-ийн 2019-2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд үндэслэн гаргав.

¹ Хууль зүйн сургууль нь цалин, орон тоог төлөвлөхдөө профессорын орон тоотой “МУИС-д профессор багш ажиллуулах журмын”-ын 8.3, 8.4-р заалтыг хангаж ажиллан цалингийн санд хяналт тавихад анхаарч байх нь зүйтэй. <https://www.num.edu.mn/filesnum/juram/NUM-professor-ajilluulah-juram.pdf>

Хүснэгт 9. Хууль зүйн сургуулийн багш нарын 2022-2023 оны хичээлийн жилийн цагийн тооцооны нэгтгэл

№	Тэнхимийн нэр	Багшийн тоо	Төлөвлөсөн цаг	Гүйцэтгэсэн цаг /намын улирал/	Гүйцэтгэсэн цаг /хаврын улирал/	Гүйцэтгэсэн цаг /бүтэн жилээр/	Илүү цаг
1	Хувийн эрх зүйн	20	262.4	159.6	224.2	380.6	118.2
2	Нийтийн эрх зүй	42	459.6	331.6	313.0	644.6	185.0
	Нийт дүн	62	722.0	491.2	537.2	1025.2	303.2

Эх сурвалж: Сургалтын үйлчилгээний ажилтны тайлангаас

Эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлд - “эрх зүй” сэтгүүлийг жилд 4 удаа гаргаж, гадаад хэл дээр тогтмол гаргах ажлыг эхлүүлэх, судалгааны төвүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагад үндэслэсэн онолын судалгааны ажлыг дэмжих, багш-судлаач-нийгэмд манлайлагч байх зорилгын хүрээнд багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжиж (МУИС-ийн цахим номын санд багш нарын бүтээлийг байршуулах, хуулбарлахаас хамгаалах, хууль зүйн салбарын бүтээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Легал дата платформыг судлах), судалгааны төвүүдээр дамжуулан олон улсын болон дотоодын санхүүжилттэй судалгаанд оролцуулах, гадаадын их дээд сургуультай хамтарсан судалгаа хийх, тодорхой сэдвээр судалгааны ажлыг үр дүнг нийтэд хүргэх буюу өгүүлэл хэвлүүлэх, импакт фактортой сэтгүүлд нийтлүүлэх тал дээр зөвлөгөө авах, гадаадын их дээд сургуультай хамтарсан сургалт, олон улсын хурал зохион байгуулах зэргээр ажлуудын дийлэнх хувийг гаднын эх үүсвэр (Фулбрайтын сан, ДБ, Япон улсын Жайка ОУБ, ХЗДХЯ-ны хамтрагч ОУБ, БОЯ-ны хамтрагч ОУБ, Азийн сан, Ханнс Зайделын сан,

ХХЗХороо)-оор санхүүжүүлэн өөрийн орлогоор санхүүжүүлэх төсөвлөсөн дүнг 227.6 сая төгрөгөөр;

Хөтөлбөрийн чанарын үнэлгээ хийж, сургалтын чанарыг дээшлүүлэх чиглэлд - эрх зүйн хөтөлбөрийг олон улсын стандартад нийцүүлэх, шинэчлэх зорилгоор ХЗС-тай хамтын ажиллагаатай гадаадын сургуулиудтай зөвлөгөөн уулзалт зохион байгуулж, судалгаа хийх, эрх зүйн хөтөлбөрт үнэлгээ хийх, оюутны онол болон практик мэдлэгийг зохистой олгох ажлын хүрээнд дутагдалтай талыг олж илрүүлэх, тэдгээрийг арилгах, либерал артын зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд мэргэшсэн боловсон хүчин бэлтгэхийг анхаарч сонгон хичээлийн төрөл, хичээлийн уялдаа холбоог сайжруулах, зайны сургалт, цахим хичээлийн хэрэгжилт, сайжруулах үнэлгээ хийх, зарим хичээлийг өвөл, зуны семестр судлах боломжийг нээх, шилдэг боловсон хүчин бэлтгэх, оюутнуудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх хүрээнд олон улсын болон дотоодын тэмцээнд оролцуулах, дадлагажих чиглэлийг анхаарч, шинэ төрлийн дадлагын хэлбэрийг нэвтрүүлэх дадлагын чиглэлийг өргөжүүлэх чиглэлээр ажиллан сургалтын үйлчилгээний зардлыг 154.9 сая төгрөгөөр;

Оюутны хөгжил,үйл ажиллагааг дэмжих чиглэлд - оюутны зөвлөл, клубүүдийн үйл ажиллагааг дэмжих, тогтмолжуулах, оюутны хөгжлийг дэмжих хүрээнд улсын болон олон улсын уралдаан тэмцээн (moot court, mock trial)-д тус сургуулийн оюутнуудын оролцоог бүрэн дэмжих, оюутнуудыг судалгааны ажилд оролцуулах, судалгааны ажлыг нь дэмжих, сургуулийн хэмжээнд хэрэгжүүлж буй олон нийтийн ажилд оюутнуудыг оролцуулах, гадаадын орнуудын жишгээр оюутанд чиглэсэн үйлчилгээг оюутнуудаар гэрээний үндсэн дээр ажиллуулах тогтолцоог нэвтрүүлэх, тэнхим, судалгааны төвд оюутнуудыг ажиллуулах, дадлага хийлгэх ажлыг хэрэгжүүлэн оюутны үйлчилгээний зардлыг 25.8 сая төгрөгөөр;

Гадаад хамтын ажиллагааны чиглэлд – сургуулийн гадаад харилцааг хөгжүүлэх ажилд анхаарч хамтын ажиллагаа бүхий сургуулиудтай хамтарсан хурал зохион байгуулах, мөн гэрээт сургуулийн профессорыг эрх зүй сэтгүүлийн редактора ажиллуулах, гэрээт сургуулиудын хичээлийн хөтөлбөрийг судлах, харьцуулан өөрийн хичээлийн хөтөлбөрийг сайжруулах, гадаадын хамтын ажиллагааны хувьд түлхүү ач холбогдол өгч ажилласан байна. Япон, ХБНГУ, Сингапур, БНСУ зэрэг улсын хэд хэдэн их сургууль, сургалт судалгаа, мэдээллийн хүрээлэнтэй хамтарсан сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулан туршлага судлах, зочин төлөөлөгч хүлээн авах зэргээр гадаад томилолт, гадаад багшийн зардалд 33.0 сая төгрөг зарцуулан 47.5 сая төгрөгийн хэмнэлт гарган ажилласан байна.

Хангамж, үйлчилгээний чиглэлд - Хууль зүйн сургуулийн байрлаж байсан хичээлийн байрыг буулган өөр байр луу шилжин байрлахтай холбоотой зардалд 133.1 сая төгрөг, (нүүлгэх, мэдээллийн технологийн болон байрны урсгал засвар үйлчилгээ), сургалтын орчныг сайжруулахад төсөл хөтөлбөрийн хандиваар 27.6 сая төгрөгийн санхүүжилт хийн ажилласан байна.

Төсвийг зарлагын эдийн ангилал, зүйл заалт, зориулалтын дагуу хэмнэлттэй зарцуулан хуримтлал бий болгосон хэдий ч цаашид төсвийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулах, стратеги төлөвлөгөөний дунд хугацааны зорилтуудыг хангах бодлого, үйл ажиллагааны үр ашиг, үр дүнд чиглүүлэн нь хөрөнгө санхүүг оновчтой зохион байгуулах, төлөвлөх, захиран зарцуулах нь зүйтэй. Тухайлбал: Нийт багшид эзлэх өндөр зэрэглэлийн судлаач багш нарын хувийг нэмэгдүүлэх, судалгааны төвүүдийн эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлэх, сургалтын хөтөлбөрүүдийг олон улсад магадлуулах, эрэлтэд суурилсан зэргийн бус сургалтыг идэвхжүүлэх, түүнээс олох орлогыг нэмэгдүүлэх гэх мэт.

2024 оны эхний улирлын төсвийн гүйцэтгэл

2024 оны төсвийн орлогын гүйцэтгэл бүгд дүнгээр 3.7 тэрбум төгрөг буюу 44.8%-ийн гүйцэтгэлтэй байна. Орлогын бүтцээр нь харуулбал судалгааны төвүүд, докторантын болон гадаад оюутнуудын сургалтын төлбөрийн орлогын гүйцэтгэлийн хувь хэмжээ харьцангуй бага байна. Иймээс тайлант хугацаанд биелэлтийг хангахад анхаарах, сургууль, нэгж хоорондын оны I улирлын тооцоог хийх, авлага өглөгөө баталгаажуулах, санхүүжилтээ бүрэн хийж дуусгах шаардлага байна.

2024 оны эхний улирлын төсвийн зарлагын гүйцэтгэл 1.3 тэрбум төгрөг буюу 11.0%-тай байна. Нийт гүйцэтгэл 64.0%-ийг урсгал зардал, 0.4%-ийг хөрөнгийн зардалд, 35.9%-ийг захиргаа, төвлөрсөн сангийн төвлөрүүлэлтэд зарцуулжээ. Зарлагын бүтцээр дэлгэрэнгүй харуулбал цалин, НДШ-д 47.0%, байр ашиглалтын зардалд 1.2%, хангамж бараа материал эд хогшилд 1.1%, бараа үйлчилгээний төлбөрт 1.7%, сургалтын үйлчилгээнд 4.6%, оюутны үйлчилгээнд 0.2%, эрдэм шинжилгээ, судалгаанд 1.4%, төсөл гэрээт ажил 6.3%-ийг эзэлж байна. Цаашид төсвийн төлөвлөлт болон зарцуулалтад МУИС-ийн захирлын 2021.11.09-ны А/319 тоот тушаал “Зардлын ангилал батлах тухай” -ын хэрэгжилтийг хангаж ажиллахад анхаарах нь зүйтэй.

2.8.3 Төсвийн гүйцэтгэлд суурилсан нэг багц цагийн өртөг

Нэг багцын өртгийг төсвийн тооцооны журмын “Сургалтын багц цагийн өртөг тооцох аргачлал”, МУИС-ийн захирлын 2021.11.09-ны А/319 тоот “Зардлын ангилал батлах тухай” тушаалын дагуу үр дүнгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлд суурилан нэг оюутны багц цагийн өртгийг тооцоолон гаргалаа.

Хүснэгт 10. Нэг оюутны багц цагийн өртөг /мян.төгрөгөөр/

Нэг багцын өртөг	2019	2020	2021	2022	2023
Төсвийн гүйцэтгэлээр	128.2	89.7	108.8	113.9	129.2
Үр дүнгээр	128.5	88.2	105.6	117.8	122.8

Эх сурвалж: ХЗС-ийн төсвийн гүйцэтгэлд үндэслэв.

Хүснэгт 11. Хууль зүйн сургуулийн МУИС-ийн дотоод төслөөс авсан санхүүжилт /сая.төгрөгөөр/

Он	МУИС-ийн нийт дотоод төсөл		Үүнээс: ХЗС-ийн дотоод төсөл			Хууль зүйн сургууль өөрийн санхүүжилтээр	
	Төслийн тоо	Мөнгөн дүн	Төслийн тоо	Мөнгөн дүн	Эзлэх хувь	Төслийн тоо	Мөнгөн дүн
2023	24	530.2				-	
2022	26	586.3	1	30.0		-	-
2021	23	492.0					
2020	26	552.0				8	19.6
2019	32	646.0	1	14.6		1	5.0
2018	23	359.0	1	10.0		24	138.7
Дүн	154	3 165.5	3	54.6		33	161.3

Эх сурвалж: МУИС-ийн СИБГ болон санхүүгийн ажилтны гаргаж өгсөн мэдээ, тайлангаас

МУИС нь 2018-2023 онуудад судалгааны санхүүжилтийн журмаар олгодог өндөр түвшний судалгаа, залуу судлаачийн тэтгэлэг, зочин судлаач, докторын дараах тэтгэлэг, МУИС-ийн тэргүүлэх чиглэлийн бодлогын судалгааны төсөл, инновацын нийт 154 төсөлд 3165.5 сая

төгрөгийн санхүүжилт олгосон байна. 2018-2022 онуудад 3 төсөл, 54.6 сая төгрөгийн төслийг Хууль зүйн сургууль хэрэгжүүлсэн байна. 2018-2020 онуудад 161.3 сая төгрөгийн 33 төсөлд ХЗС-ийн өөрийн орлогоос санхүүжүүлсэн байна. ХЗС-ийн өөрийн орлогоор 2021-2023 онуудад дотоод төсөлд санхүүжилт олгоогүй байна. 2024 онд дотоод төсөл хэрэгжүүлэхээр 40.0 сая төгрөг төсөвлөсөн байна. Үүнийг багш нарын судалгаа, бүтээлийг дэмжихээс гадна мэргэжлийн зөвлөх үйлчилгээнд зарцуулахаар төлөвлөж байна. Цаашид МУИС-ийн судалгааны санхүүжилтийн журмыг мөрдлөг болгоход анхаарч ажиллах нь чухал байна.

Захиргаа, төвлөрсөн үйлчилгээ, бодлогын хөрөнгө оруулалтын төвлөрүүлэлтийн 12.9%-19.2%-ийг ХЗС санхүүжүүлж ирсэн байна.

Хүснэгт 12. МУИС-ийн бодлого, төвлөрсөн үйлчилгээний санхүүжилтэд Хууль зүйн сургуулиас санхүүжүүлсэн хувь хэмжээ /сая.төгрөгөөр/

Он	Бодлого, төвлөрсөн үйлчилгээнд	Үүнээс:		
		Бусад бүрэлдэхүүний	Хууль зүйн сургууль	ХЗС-ийн эзлэх хувь
2019	15,998.1	12,928.1	3,070.0	19.2%
2020	9,268.9	8,068.9	1,200.0	12.9%
2021	11,000.0	9,300.0	1,700.0	15.5%
2022	9,000.0	7,600.0	1,400.0	15.5%
2023	10,013.6	8,413.6	1,600.0	16.0%
Дүн	55,280.6	46,310.6	8,970.0	15.8%

2.8.4 2016-2024 оны стратеги төлөвлөгөө болон дунд хугацааны гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтүүд

Хууль сургууль нь хөгжлийн ахиц дэвшлийн гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт болон 2016-2024 оны стратегийн зорилт, завсрын зорилтуудыг тусгайлан дүгнээгүй ч тэдгээрийг хангах үйл ажиллагааны үр дүнг жил тутам хичээлийн жилийн тайлан болон МУИС-ийн захиралтай байгуулсан гэрээний үр дүнгийн тайланд дэлгэрэнгүй тайлагнасан байна. ¹

2.8.5 Нэгж, хоорондын санхүүжилт

Хууль зүйн сургуулийн сургуулиуд хөтөлбөр хоорондын экспорт импортын үйлчилгээ, хичээлийн сонголтын байдлаас харахад улиралд дунджаар 84.3 орчим хувь өөрийн сургуулийн харьяа хичээл, үлдсэн хувь нь бусад бүрэлдэхүүний сургуулийн харьяа хичээл байна.

Хүснэгт 13. Суралцагчдын хичээл сонголт багц цагаар

Он	Нийт	Үүнээс:		
		Өөрийн сургуулийн хичээл	Бусад сургуулийн хичээл	Хувь
2021	43451	36662	6789	84.38
2022	42846	36289	6557	84.70
2023	42376	35591	6785	83.99
Дундаж хувь		84.35		

Бүх бүрэлдэхүүний сургуулиуд нь гарц бүтээгдэхүүний сургалтын хөтөлбөрийн загвар гарган түүнд чиглэсэн үйлчилгээг бүрэлдэхүүн нэгжүүдэд үзүүлэх. Си-си системийн экспорт,

¹ Хууль зүйн сургуулийн 2022-2023 оны хичээлийн жилийн тайлан, МУИС-ийн захиралтай байгуулсан гэрээний гүйцэтгэлийн тайлан.

импортын тайлан, хоорондын тооцооны дэлгэрэнгүй тайланг хянах, дүн шинжилгээ хийх, дотоод тооцоог бусад нэгжүүдтэй тулган баталгаажуулах нь сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд ач холбогдолтой. Дотоод тооцоог төсөвлөсөн сууриар тайлагнах.

2.8.6 Элсэлт, шилжилттэй холбоотой

Хууль зүйн сургууль нь бакалаврын 1, мэргэжлийн болон судалгааны магистрын 1, докторын 1 хөтөлбөрөөр элсэлт авч үйл ажиллагаа явуулж байна. Элсэлтийг 100 хувь хангаж ажилладаг. Оюутан суралцагчдын хөдөлгөөн сүүлийн 5 жилийн дунджаар 1 оюутан шилжин явахад, 2-3 оюутан шилжин ирдэг мэдээлэл байна. Шилжин явж байгаа хөдөлгөөн нь нийт идэвхтэй суралцагчдын 1.1-1.5 хувийг эзэлж байгаа нь орлогын дүнд нөлөөлөх хувь хэмжээ бага байна. Өөрөөр хэлбэл сургалтын төлбөрийн орлогын өөрчлөлтөд шилжих хөдөлгөөний нөлөөлөл сул байгааг илтгэж байна.ⁱⁱ

2.8.9 МУИС-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийн мөрөөр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

Өмнөх оны хөндлөнгийн аудитаас өгсөн зөвлөмжийг анхаарч мөрдөж ажиллах.

2.6.10 Дотоод аудитын илрүүлэлтийн талаар:

Илрүүлэлт:

Хууль сургуулийн захирлын 2023.11.24-ны А/162 тоот тушаалаар “V түвшний оюутны мэргэших дадлага удирдагчийн хөлсийг 155,000 төгрөг” - өөр тогтоон мөрдөж байгаа нь МУИС-ийн захирлын 2023.12.14-ны А/594 тоот “Цагийн хөлсний үнэлгээг шинэчлэн тогтоох” тухай тушаалтай нийцэхгүй байна.

Зөвлөмж, санал:

Тус хөлсний үндэслэл, аргачлалыг боловсруулан МУИС-ийн захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулах;

Илрүүлэлт:

МУИС-ийн захирлын 2014 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн А/21 тоот тушаалыг үндэслэн санхүүжилтийг олгож ажилласан байна.

Санал:

Санхүүгийн эрх шилжүүлэх дээрх тушаал тушаал хүчинтэй эсэх талаар холбогдох нэгжээс тодруулах.

Асуудал, эрсдэл:

- Санхүүгийн ажилтнууд тогтворгүй, олон удаа солигдох;
- Санхүүгийн шинэ программ нэвтрүүлэлт удаашрах;
- Нягтлан бодох бүртгэлийн стандартын тодорхой бус байх;
- Санхүүгийн ажилтнуудын туршлага, мэргэшсэн байдал сул байх;
- Санхүүгийн үйл ажиллагааны журам, НББ-ийн бодлогын баримт бичиг, төсвийн тооцооны журам зэрэг холбогдох журмуудын нэмэлт, өөрчлөлт хийгдэхгүй, санхүүгийн ажилтнуудыг нэгдсэн удирдлага, гарын авлагаар хангахгүй байдлаас үүдэн тайланг бэлтгэх, нэгтгэх, санхүүгийн үйл ажиллагааг хэвийн явуулахад эрсдэлийг бий болгож болзошгүй байна.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

- Хууль зүйн сургууль нь нийтийн болон хувийн эрх зүй гэсэн мэргэжлийн хоёр тэнхимтэй, сургалтын үйл ажиллагааг эрхлэн явуулдаг байна. "Практик сургалтын төв", Японы болон Солонгосын эрх зүйн боловсролын төв, "Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн", "Эдийн засаг, бизнесийн эрх зүйн төв", "Харьцуулсан эрх зүй, олон улсын эрх зүйн төв" гэсэн төвүүдээр дамжуулан зэргийн бус сургалт, судалгааны үйл ажиллагаа явуулж байна.
- 2023 оны статистикаар тус сургууль 1 удирдлага, 63 багш, үндсэн багшийн 25.5% эрдмийн цол, зэрэгтэй, 19 ажилтантай, 2333 суралцагчдаас 1535 суралцагч буюу 65.8 хувийн идэвхтэй, батлагдсан бүтэц орон тооноос сул орон тоо 3.5 хувьтай байна.
- Санхүүгийн байдлын хувьд нийт хөрөнгө 6,683.3 тэрбум төгрөг үүний 6,141.3 төгрөг буюу 91.9% эргэлтийн хөрөнгө, үлдсэн 541.9 сая төгрөг буюу 8.6% эргэлтийн бус хөрөнгө байна. 2019-2023 онуудад нийт хөрөнгийн 90.0 хувиас буурахгүй өөрийн эх үүсвэрээр буюу гадаад эх үүсвэрээс хараат бусаар үйл ажиллагааны урсгал болон хөрөнгө оруулалтын зардлаа санхүүжүүлсэн байна. Эх үүсвэр өмнөх онуудаас тогтвортой нэмэгдэж, сургалтын төлбөрөөр төсөвлөсөн зардлаа бүрэн нөхөн тодорхой хэмжээний хөрөнгө оруулалтын хуримтлал бий болгосон байна. 2023 оны санхүүгийн үр дүнг эерэг боловч жил тутам буурсан үзүүлэлттэй байгаа нь эх үүсвэр хумигдаж байгааг илтгэж байна.
- Өөрийн хөрөнгийн 1 төгрөгт ноогдох өөрийн харьцаа он дараалан буурсан, сургалтын үйл ажиллагааг санхүүжүүлэх өөрийн хөрөнгө (ажлын капитал) тогтвортой нэмэгдсэн, эргэлтийн хөрөнгийн харьцаа өссөн зэрэг нь тус сургууль санхүүгийн хараат бус байдлаар өөрийгөө санхүүжүүлэх чадвартайг илтгэж байна. Гэхдээ сургуулийн хичээлийн байрны хөрөнгө оруулалтыг хийснээр өөрийн хөрөнгө (ажлын капитал) буурч сургуулийн санхүүгийн тогтвортой байдалд нөлөөлөх, бусад үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр хумигдах эрсдэл байгаа тул санхүүгийн бие даасан байдлыг хангах, орлогын бусад сувгуудыг дайчлан ашиглах, төсвийн зарцуулалтын удирдлага, хяналтыг өөрчлөх шаардлага бий болохыг анхаарч ажиллах нь зүйтэй.
- Төлбөрийн ойрын болон өнөөгийн боломж хэвийн нормоос илүү, урсгал зардал, хөрөнгө оруулалтын тодорхой хувийг өөрийн эх үүсвэрээр санхүүжүүлж МУИС-ийн бодлого, төвлөрсөн үйлчилгээний 12.0-19.0 орчим хувийг санхүүжүүлж байгаа хэдий ч үйлчлүүлэгчдийн төлбөрийн чадвар, нийгэм, эдийн засаг, улс төрийн хүчин зүйлсийн нөлөөллийг тооцон цугларуулсан санхүүжилт (хуримтлал болон сургалтын төлбөрийн)-ийг зөв байршуулан, оновчтой ашиглан санхүүгийн ямар нэг хүндрэлд орох эрсдэлийг тооцон ажиллах нь зүйтэй байна.
- 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд орлогын төлөвлөгөө нийт дүнгээр 1.44 хувиар давсан бол орлогын бүтцээр сургалтын төлбөрийн орлого 2.22 хувиар тасарч, бусад орлогын нэмэлтээр хангасан байна. Сургалтын төлбөрөөс бусад эх үүсвэрийг нэмэгдүүлэх чиглэлд төрийн болон ОУБ-аас эх үүсвэр татан сургалт, эрдэм шинжилгээ, оюутны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажилласан байна.
- Орлого үр дүнгийн тайлангийн дүнгээр стратеги төлөвлөгөөний хүрээнд тус сургуулийн дунд хугацаанд хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан байгууллагын бие даасан байдал болон санхүүгийн тогтвортой байдлыг хангахад сургалтын төлбөр болон улсын төсвөөс бусад орлогыг нийт орлогын 4 хувиас доошгүй хувь байх зорилт хангагдсан байна. Үүнд хадгаламжийн хүүгийн болон төсөл хөтөлбөр, гэрээт ажил, судалгааны орлого гол нөлөө үзүүлжээ.
- МУИС-ийн захирлын 2014.02.07-ны А/21 тоот тушаалын дагуу "Батлагдсан төсвийн хүрээнд багш, ажилтны цалин хөлстэй холбоотой зардлууд, бараа үйлчилгээний

зардал, сургалтын үйлчилгээний зардал, гэрээт эрдэм шинжилгээний төсөл хөтөлбөрийн зардал гаргах” шилжүүлсэн эрхийн хүрээнд батлагдсан төсвийг эдийн ангилал, зүйл заалт, зориулалтын дагуу үндсэн үйл ажиллагааны чиглэлүүдэд хэмнэлттэй зарцуулан, мөнгөн хөрөнгийг оновчтой байршуулах, илүү өгөөжтэй ашиглах тал дээр анхаарч ажилласан байна. Төсвийн зарцуулалтад анхаарах зарим асуудал байгааг дурдвал: мэргэжлийн дадлагын хөлсийг өгсөн зөвлөмжийн дагуу тогтоон мөрдөх, гадаад томилолтын зардлын өгөөж, үр дүнг нэмэгдүүлэхэд анхаарах холбогдох дотоод журмыг мөрдлөг болгох шаардлагатай байна.

- Сургуулийн нийт урсгал зардлын 74.1 хувийг цалин, НДШ эзэлж байна. Багшийн ногдлын гүйцэтгэл, анги бүрдэлтэд хяналт тавин ажилласнаар сургалтын үйл ажиллагааг илүү үр дүнтэй зохион байгуулах замаар сургуулийн үр дүнг нэмэгдүүлэх боломж байна гэж үзлээ.
- Сургуулийн нийт хөрөнгийн цэвэр хэмжээ буурч үндсэн хөрөнгө 58.0%-ийн элэгдэлтэй байгаа нь сургалт судалгааны орчны шинэчлэлд анхаарах шаардлага байгааг илтгэж байна.
- Нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, тайланг бэлтгэх, нэгтгүүлэхтэй холбоотойгоор стандартыг тодорхой болгон НБББББ-д (аудитын зөвлөмжөөр гарсан) өөрчлөлтүүдийг оруулах шаардлагатай нягтлан бодох бүртгэлийн дараах асуудлуудыг тусгахгүй бол санхүүгийн тайлагнал үнэн бодитой тайлагнагдахгүй байх эрсдэл байна. Тухайлбал: орлогын бүртгэлийн тусгай бодлогод тусгагдсан сургалтын төлбөрийн орлогын хүлээн зөвшөөрөлт, санхүүгийн үр дүнгийн тайланд тусгагдсан дотоод тооцоо, мөнгөн гүйлгээний тайлангийн тохируулгаар хийгдэх төсвийн гүйцэтгэлийн тайлан гэх мэт;
- Сургалтын төлбөрийн орлогыг Сиси системийн хичээл сонголттой тулган баталгаажуулаагүй, нэгжүүдийн дотоод тооцоог нийлээгүй тухайн ондоо багтаан өглөг авлагаа барагдуулаагүй байна. Энэ нь дотоод тооцоо мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэлд зөрүү үүсэхэд нөлөөлжээ;
- Батлагдсан төсөвт эдийн засгийн зүйл заалт зөрүүтэй байдал ажиглагдаж байна. Төсвийн төлөвлөлтөд холбогдох эдийн засгийн ангиллыг мөрдөх;
- Санхүүгийн хуучин программ ашиглах боломжгүй, шинэ программын нэвтрүүлэлт удаашралтай байна. Шинэ программд өмнөх оны эхний ҮХ, БМ, авлага, өглөгийн өгөгдлүүд, эхний үлдэгдлүүдийг шивсэн. Шинэ программ дээр цалин бодох тохиргоонууд хийгдээгүй байна. Бараа материал, хөрөнгийн эргэлтийн гүйлгээ хийх тохиргоо хийгдээгүйгээс падаануудыг цуглуулж байна. 1-2 сард нөхөж оруулсан, тайлангуудаа засварлах боломжгүй, өмнөх гүйлгээ, падаанаар харах боломжгүй байна. Санхүүгийн бүртгэл болон төсвийн гүйцэтгэлийг системээс гаргах боломжгүй excel, цалин хөлс НДШ-ын тайланг хуучин систем дээр хийж байна. Энэ нь нягтлан бодогч нарт хиймэл ачаалал үүсгэхээс гадна нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, санхүүгийн тайланг бэлтгэх, нэгтгэх, санхүүгийн үйл ажиллагааг хэвийн явуулахад эрсдэлийг үүсгэж болзошгүй байна;
- Цалин, НДШ-ийн тайлан тооцоо, бараа материалын эргэлт, үндсэн хөрөнгийн бүртгэл тооцоог шинэ программаар бодох, хөтлөх, тайлагнах нөхцөл боломж бүрдээгүй байна. Үүнээс улбаалан бараа материал, үндсэн хөрөнгийн оны гүйлгээнүүд хуримтлагдаж байна;
- Шилэн дансны хэрэгжилт болон анхан шатны баримт бүрдүүлэлт хангалттай сайн, хөндлөнгийн аудитаас өгсөн зөвлөмж хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

ЦААШИД АНХААРАЛ АСУУДЛУУД, САНАЛ ЗӨВЛӨМЖ

Санхүүгийн үйл ажиллагаатай холбогдох дүрэм журмын хэрэгжүүлэх чиглэлд: - Санхүүгийн үйл ажиллагаатай холбогдох дотоод журам, тушаал шийдвэрийг судлах, үйл ажиллагаандаа мөрдлөг болгох, сургуулийн хөрөнгө санхүүг цаашид сургуулийн урт хугацааны бодлогыг хэрэгжүүлэх дунд болон богино хугацааны төлөвлөлтөд чиглүүлэн стратеги төлөвлөгөөний шалгуурыг хангахад оновчтой зохион байгуулах, төлөвлөх, захиран зарцуулах; Тухайлбал: Нийт багшид эзлэх өндөр зэрэглэлийн судлаач багш нарын хувийг нэмэгдүүлэх, судалгааны төвүүдийн эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлэх, сургалтын хөтөлбөрүүдийг олон улсад магадлуулах, эрэлтэд суурилсан зэргийн бус сургалтыг идэвхжүүлэх, түүнээс олох орлогыг нэмэгдүүлэх зэргээр сургуулийн чадавхыг бэхжүүлэхэд анхаарах.

Сургалтын төлбөрөөс бусад орлогын эх үүсвэрийг бүрдүүлэх хөрөнгө татах чиглэлд – Судалгааны төвүүдийн болон зэргийн бус хөтөлбөрийн орлогыг нэмэгдүүлэхэд анхаарах;

Санхүүгийн тайлагнал сайжруулах чиглэлд – а/шийдвэр гаргалт, удирдлагын мэдээллийн ач холбогдол, үнэ цэнтэй байдлыг ханган ажиллахад анхаарах, нээлттэй өгөгдөл, дата бааз бүрдүүлэхэд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх; б/ санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлд шинжилгээ хийх, холбогдох аргачлалын дагуу бүтээгдэхүүний өртгийн тооцоог тогтмолжуулах; в/сургууль хоорондын тооцоо, хичээл сонголт, харилцахын орлогын гүйлгээг тулган тооцоо нийлэх, г/ сургалтын төлбөрийн орлого, дотоод тооцооны хяналтыг сайжруулах, авлага, өглөг, УОО, УГЗ-ын тооцоо нийлэх, төв санхүүгээр тулган баталгаажуулах;

Бараа материал, эд хөрөнгөнд хяналт тавих чиглэлд - Бараа материалын оршин байгаа эсэхэд удирдлагын болон санхүүгийн ажилтнуудын хяналтыг сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулах (бараа материалын шошго ашиглах, тооллого хийх);

Сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах чиглэлд – Сургалтын үйл ажиллагаатай холбоотойгоор Сиси системийн багшийн ногдлын тайланг харах эрхийг сургуулийн захирал, тэнхимийн эрхлэгч, ахлах нягтлан бодогч нарт өгөх, үүгээр дамжуулан сургалтын үйл ажиллагаа, багшийн ногдол, гүйцэтгэлд хяналт тавих, сургалтын үйл ажиллагааг илүү үр дүнтэй зохион байгуулах боломжийг олж харах, түүнчлэн МУИС-д профессор, багш ажиллуулах журмын 13 дугаар зүйл “Багшийн цагийн ногдлыг төлөвлөх, дүгнэх, хянах”-зүйлийн 13.1, 13.2, 13.3, 13.4 заалтыг хангаж ажиллах шаардлагатай байна;

Санхүүгийн программ хангамжийн нэвтрүүлэлтийн чиглэлд: - Санхүүгийн программын нэвтрүүлэлт бүрэн дуустал сургуулийн төсвийн шууд захирагч бүх шатандаа дотоод хяналтыг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна;

Төсөв, санхүүгийн ажилтан нарыг мэргэжлийн болон хуулийн өөрчлөлтүүдийн сургалт, семинарт хамруулах - Шинээр ажилд орсон ажилтныг холбогдох дотоод дүрэм журмаар чиглүүлэх;

МУИС-аас мэргэжлийн бодлого удирдамжаар хангах чиглэлд - Байгууллагын өмчийн хэлбэртэй холбоотойгоор санхүүгийн тайланг бэлтгэх стандарт шинэчлэгдээгүй байгаа нь санхүүгийн ажилтнуудад эрсдэл үүсгэж болзошгүй байна. НБББББ болон холбогдох журмыг яаралтай шинэчлэн батлуулан санхүүгийн тайланг хөтлөх, бүртгэх, бэлтгэхэд дэмжлэг үзүүлэн ажиллах шаардлагатай байна. Үүнд:

- Санхүүгийн үйл ажиллагааны журам, НББ-ийн бодлогын баримт бичиг, төсвийн тооцооны журам зэрэг холбогдох журмуудыг шинэчлэн сайжруулах, нэгжүүдийг мэргэжлийн удирдлага, гарын авлагаар хангах;
- Нягтлан бодогч нарын мэргэшсэн байдалд анхаарах, дотоод хяналтыг сайжруулах;
- Санхүүгийн системийг яаралтай бүрэн ашиглалтад оруулахад анхаарал хандуулах, төсвийн гүйцэтгэлийг цахимаар хянах нөхцөл боломжийг төсвийн шууд захирагч нарт бүрдүүлэх;
- Төвийн удирдлагууд нэгжийн санхүүгийн ажилтнуудтай ярилцаж НББ, төлөвлөлт, төсөвлөлт, гүйцэтгэлийг сайжруулах;
- Гаднын эх үүсвэрээр санхүүжигдэх судалгаа, төсөл, гэрээт ажил, зөвлөх үйлчилгээний эрх зүйн орчныг сайжруулахад дэмжлэг үзүүлэх;
- ХЗС дээр хэрэгжиж буй дотоод төслөөр зөвлөх үйлчилгээний санхүүжилтийг төлөвлөх, төсөвлөх талаарх холбогдох журмуудад зохицуулалт хийх.

ⁱ [SISI-MYIC \(num.edu.mn\)](http://SISI-MYIC(num.edu.mn))

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

ДОТООД АУДИТОР:Д.ТУНГАЛАГ

ТАНИЛЦСАН: ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛИЙН

ЗАХИРАЛ: Б.АМАРСАНАА

АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ Б.БАДАМХАНД

ⁱⁱ Хууль зүйн сургуулийн сургалт хариуцсан мэргэжилтний мэдээ